

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2022/7/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Даланзадгад хот 2022 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533539 Цахим хаяг: tserenbayars@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс аудит” ХХК Захирал: Ш.Ичинхорлоо Утас: 77270808 Цахим хаяг: nitsbalance@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЯН-ОВОО
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ц.НАРАНТУЯА
ТАНАА

2022.02.23 № 190

танай _____-ны № _____-г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 С.ЦЭРЭНБАЯР

D:\2021 Он\Бичиг Хэрэг\Явсан Бичиг\2022-02-23 №190

016070338

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	63.3	84.4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,089.5	4,052.1
	Нийт хөрөнгийн дүн	4,152.8	4,136.5
	Нийт өр төлбөрийн дүн		-0.2
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,152.8	4,136.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,152.8	4,136.5
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	3,806.5	774.9
	Үйл ажиллагааны зардлын дүн	667.0	786.9
	Үйл ажиллагааны үр дүн	3,139.5	(12.0)
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-4.6
	Үйл ажиллагааны нийт үр дүн	3,139.5	(16.5)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	858.5	858.5
	Тайлант оны үр дүн	3,294.3	3,277.7
	Эцсийн үлдэгдэл	4,152.8	4,136.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	663.3	751.0
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	651.8	744.7
	Үйл ажиллагааны ЦМГ	11.5	6.3
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	11.5	6.3
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(11.5)	(6.3)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	730.0	706.4
	Урсгал зардал	730.0	706.4
	Хөрөнгийн зардал	-	0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	730.0	706.4

	Улсын төсвөөс санхүүжих	544.2	521
	Орон нутгийн төсвөөс	185.8	185.4
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын ерөнхий боловсролын сургууль нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад бүх талуудтай хамтран ажиллах” гэж тодорхойлсон ба үйл ажиллагааны дараах чиглэлтэй байна. Үүнд:

- Хүүхэд бүрийг тэгш хамруулан сургах боломж, нөхцлийг бүрдүүлж, сурлагын хоцрогдолыг арилгахад чиглэсэн ажлуудыг үр дүнтэй зохион байгуулж, сургууль завсардалтгүй сургах.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дэлхийн нийтээр Ковид-19 өвчлөлтэй холбоотойгоор БШУЯ-ны сайдын тушаалын дагуу сургалтын үйл ажиллагааг 3, 9, 10, 11, 12 саруудад буюу 5 сар танхимаар болон цахимаар хосолсон хэлбэрээр явуулсан байна.

Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Сургалтын чанар, багшийн хөгжил, орчны эрүүл ахуй, эцэг эхийн оролцоо зэрэг арга хэмжээ хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж “ШИЛДЭГ СУРГУУЛЬ” болсон байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлан бэлтгэх аргачлал, стандарт болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй тул санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

Долоо. Аудитын илрүүлэлт:

7.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

[illegible]

